



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 2/556

Хэрлэн сум

Мотоцикл, мопед, цахилгаан дугуй,
унадаг дугуйн хөдөлгөөнийг түр хугацаагаар
хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.4.3, 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Зорчих хэсгийн гадаргуу цасаар хучигдсан халтиргаа гулгаа үүсэж тээврийн хэрэгслийн зорчих хэсгийн нөхцөл байдал хүндэрсэн үед мотоциклоор замын хөдөлгөөнд оролцогчдын эрүүл мэнд, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол эрсдэлийг багасгах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт мотоциклтой замын хөдөлгөөнд оролцохыг 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл түр хугацаагаар хязгаарласугай.

2. Хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, ард иргэдэд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга сэрэмжлүүлэг өгч сурталчлах ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай хүргэж, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Цагдаагийн газрын дарга (цагдаагийн дэд хурандаа Э.Жавхлантөгс), сумдын Засаг дарга нар тус тус даалгасугай.

3. Захирамжид тусгагдсан арга хэмжээний үр дүн, явц байдлыг Цагдаагийн газрын дарга, сумдын Засаг дарга нарт танилцуулж, хойшид авах арга хэмжээний саналыг оруулж байхыг сумдын Засаг дарга, Цагдаагийн газрын дарга, (цагдаагийн дэд хурандаа Э.Жавхлантөгс) нарт тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ